

Увс аймгийн Өмнөговь сум

**“ТӨРӨЛХ НУТГАА
ХӨГЖҮҮЛЬЕ”**

**2020 ОНЫ ӨМНӨГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД 3-Р БАГТ
БИЕ ДААН НЭР ДЭВШИХ
СЭТЭНЖАВ ОВОГТОЙ БАТМӨНХИЙН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 он

**Увс аймаг Өмнөговь сумын ИТХ –ын 2020 оны ээлжит сонгуулийн
3-р багт БИЕ ДААН нэр дэвшигч Шангас овогт Сэтэнжавын**

Батмөнхийн мөрийн хөтөлбөр

**НЭГ.БАГИЙН АРД ИРГЭДИЙН АМЬЖИРГАА, ӨРХИЙН ОРЛОГО,
АМЬДРАЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР**

1. Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг малчдад чиглүүлж малчдын уламжлалт ахуй болох малын түүхий эд боловсруулах ажилд түлхүү зарцуулж ажиллах талаар онцгой анхаарна.
2. Багийн ард иргэдийг нөхөрлөл хоршоолол болоход нь тусалж, айл өрхүүдийг хамтарч хот саахалтын уламжлалыг сэргээж ажиллахад нь тусална.
3. Малыг эрүүлжүүлэх, ашиг шимийг дээшлүүлэх, үүлдэр угсаа сайжруулж , багийн эцэг малын сан хөтөлбөр боловсруулж ажиллана.
4. Малчин өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэднийг ЖДҮДС-ийн зээл, Амьжиргаа дэмжих сангийн зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулахад анхаарч ажиллана.
5. Төсөвт байгууллагуудын мах, сүүний тендерт малчин болон малчдын бүлгийг хамруулах талаар сумын тендерийн хороотой хамтарч ажиллана.

ХОЁР.БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛАХ ТАЛААР

- 1 Орлогын голд хайгуулын болон ашиглалтын лицензтэй компаниудыг ажиллуулахгүй байх талаар бүх бололцоогоо дайчлан үргэлжлүүлэн ажиллана.
- 2 Гар аргаар алт олборлож байгаа хүмүүсийн ухсан нүхийг нь нөхөн сэргээлгэх зорилгоор багийн ард иргэдтэй хамтарч сумын ИТХ-ын журам боловсруулж ажиллана.
- 3 Ховор ан амьтан болон соёлын өв дурсгалыг хамгаалах, бүртгэлжүүлэх, бүртгэлтэй соёлын өвийн хамгаалалтын урамшууллыг ард иргэдэд олгуулах талаар ИТХ-ын журам боловсруулна.
- 4 Ногоон цэгээний рашааныг хамгаалах , сурталчилах, нийтийн хүртээл болгох ажил зохион байгуулна.
- 5 Сумын аялал жуулчлал, түүх, соёлын дурсгалын зураг ба аяллын маршрутын зураглал гаргаж ажиллах талаар сумын ИТХ, холбогдох хүмүүстэй хамтарч ажиллана.
- 6 Түгээмэл тархацтай байгалийн баялгийн хууль бус олборлолтын хяналт шалгалтыг сайжруулж, төлбөр үнэлгээг мөрдүүлэх талаар санаачлагатай ажиллана.

**ГУРАВ.ТӨСӨВ САНХҮҮ, ИТХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ
ХАНГАХ ТАЛААР**

- 1 Сумын ИТХ-аар баталдаг төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.
- 2 ОНХС, ЖДҮДС, амьжиргаа дэмжих санд ард иргэдийн оролцоог хангуулах, хяналт тавих талаар онцгой анхаарна.
- 3 Сумын ИТХ-ын хуралдааныг нээлттэй хийх ажлыг хэвшил болгуулж, ард иргэдийн оролцоог хангаж ажиллана.
- 4 Жилд нэг удаа багийн айл өрхүүдээр явж санал бодлыг нь сонсож шаардлагатай саналыг сумын хуралд хүргэж ажиллана.

ДӨРӨВ.БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ТАЛААР

- 1 Бэлчээрийн даацыг судалж, сумын ЗТТГ-н мэргэжилтнүүдтэй хамтарч малчдын саналыг харгалзан шинээр уст цэг байгуулахад санаачлагатай ажиллана.
- 2 Бэлчээр хамгаалах сумын хөтөлбөр сумын ИТХ-аар боловсруулж ажиллана.
- 3 Голын ай сав газарт тэжээлийн ургамал болох царгас тариалахад бүх талаар дэмжиж, хадлангийн газрын хуваарь гаргуулах , Ховдын голын хадлангийн тэгш оролцоог хангуулж ажиллана.
- 4 Малчдын бэлчээр хамгаалах нүүдэл хөтөлбөр боловсуулж, тэмээгээр нүүж буй өрх бүрт урамшууллын бодлогыг санаачлана.
- 5 Хамгийн хол тэмээгээр нүүдэлж буй өрх шалгаруулж, жил бүр алдаршуулах ажлыг зохион байгуулна.
- 6 Сум , Аймаг, Улсын сайн малчдын болзол хангасан малчдыг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцдэг журмыг хатуу баримтална.
- 7 Малжуулах журам хангасан мал цөөнтэй иргэдийн амьдрал байдлыг харгалзан багийн нийтийн хурлаар хэлэлцдэг болох
- 8 Өвөлжөө, намаржааны хуваарь зоцуулах сумын нэгдсэн журам санаачилна.
- 9 Ховд сумын зарим иргэд болон төр захиргааны байгуулаагын хууль бус тулгалт, хууль бус татвар хураамж, ыторгууль ноогдуулалтыг таслан зогсооно.